



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрүүл мэндийг дэмжих сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** СНАГ-2024/02/НА-СТА-ЗГТС

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2024 он</p>	<p>Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: <a href="mailto:naranchimegts@audit.gov.mn">naranchimegts@audit.gov.mn</a> Аудитын менежер: Ц.Хосжаргал Утас: 261885 Цахим хаяг: <a href="mailto:khosjargalts@audit.gov.mn">khosjargalts@audit.gov.mn</a> Ахлах аудитор: В.Эрдэнэцогт Утас: 261628 Цахим хаяг: <a href="mailto:erdenetsogtv@audit.gov.mn">erdenetsogtv@audit.gov.mn</a></p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ТӨРИЙН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Д.ОЧИРБАТ  
ТАНАА

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2024.03.25 № 07/823  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Эрүүл мэндийг дэмжих сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн хүрээтэй тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Эрүүл мэндийг дэмжих сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон 21.7 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр байна. Үүнд:

- Тайлант онд төслийн урьдчилгаа төлбөр олгосныг зардалд шууд бүртгэсэн, үйл ажиллагааны болон мөнгөн урьдчилгааны тайлан ирүүлээгүй, гэрээ дүгнэж акт үйлдээгүй 209.7 сая төгрөг;
- Өмнөх онуудад олгосон төслийн урьдчилгаа он дамжсан, гэрээний үүргийн хэрэгжилтийг хангуулаагүй 164.1 сая төгрөг;
- Төслийн ажлын тайлангуудыг хугацаа хоцроосонд гэрээний алданги тооцоогүй 174.5 сая төгрөг;
- Гэрээний үүргээ биелүүлээгүй, ирүүлсэн төслийн саналыг эрэмбэлээгүй, явцын хяналт хэрэгжүүлээгүй

зэрэг зөрчил нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.11, Эрүүл мэндийг дэмжих сангийн үйл ажиллагааг зохицуулах журмын 3.3.1, 3.3.2, 3.6.2, 3.7.2, 3.7.3, 3.7.4, Ажил гүйцэтгэх гэрээний 6.1-д тус тус заасантай нийцээгүй, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Z:\Yawsan\_Bichig\2024\0325 SNAG-30.Docx

0001051059

## Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийн дэмжих сангаас 2023 онд халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 703.1 сая төгрөг, сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, архи, тамхи, мансууруулах бодисын хорт нөлөөллөөс сэргийлэх чиглэлээр 412.7 сая төгрөг, осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, эрүүл, аюулгүй амьдралын орчныг бүрдүүлэх чиглэлээр 305.1 сая төгрөг, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, эрүүл мэндийн байгууллагын ил тод байдал, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр 159.9 сая төгрөг, орчны эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр 109.7 сая төгрөг, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 69.9 сая төгрөг, эмийн зохистой хэрэглээг сурталчлан таниулах чиглэлээр 36.7 сая төгрөг, нийт 1,797.1 сая төгрөгийн 59 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр сонгон шалгаруулалт явуулж, 58 гэрээ байгуулсан байна.

## Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн сайдын 2023 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн А/147 дугаар тушаалаар “Эрүүл мэндийг дэмжих сангийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг анх удаа баталсан байна.

## Бусад асуудлын хэсэг

Эрүүл мэндийг дэмжих сангаас санхүүжих төслийн сонгон шалгаруулалт, хэрэгжилтэд тавих хяналтыг Нийтийн эрүүл мэндийн газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, зохион байгуулсан байна.

## Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>864,051,960.00</b>	<b>618,541,993.00</b>
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>864,051,960.00</b>	<b>618,541,993.00</b>
34600	Урьдчилж гарсан зардал	864,051,960.00	618,541,993.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>864,051,960.00</b>	<b>618,541,993.00</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>7,482,000.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>7,482,000.00</b>
41300	Өглөг	-	7,482,000.00
41360	Бусад өглөг	-	7,482,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	7,482,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>864,051,960.00</b>	<b>611,059,993.00</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	864,051,960.00	611,059,993.00
51200	Хуримтлагдсан үр дүн	864,051,960.00	611,059,993.00
51210	Өмнөх үеийн үр дүн	1,033,046,569.00	864,051,960.00
51220	Тайлант үеийн үр дүн	(168,994,609.00)	(252,991,967.00)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>864,051,960.00</b>	<b>618,541,993.00</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,835,000,000.00</b>	<b>1,907,341,259.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,835,000,000.00</b>	<b>1,907,341,259.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,835,000,000.00</b>	<b>1,907,341,259.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,835,000,000.00	1,907,341,259.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,003,994,609.00</b>	<b>2,160,333,226.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,003,994,609.00</b>	<b>2,160,333,226.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,003,635,406.00</b>	<b>2,061,342,699.00</b>
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3,003,635,406.00</b>	<b>2,061,342,699.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,003,635,406.00	2,061,342,699.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>359,203.00</b>	<b>98,990,527.00</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>359,203.00</b>	<b>98,990,527.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	359,203.00	98,990,527.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>(168,994,609.00)</b>	<b>(252,991,967.00)</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>(168,994,609.00)</b>	<b>(252,991,967.00)</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,835,000,000.00</b>	<b>1,907,341,259.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,835,000,000.00</b>	<b>1,907,341,259.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,835,000,000.00</b>	<b>1,907,341,259.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,835,000,000.00	1,907,341,259.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,835,000,000.00</b>	<b>1,907,341,259.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,835,000,000.00</b>	<b>1,907,341,259.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,834,640,797.00</b>	<b>1,808,350,732.00</b>
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,834,640,797.00</b>	<b>1,808,350,732.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,834,640,797.00	1,808,350,732.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>359,203.00</b>	<b>98,990,527.00</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>359,203.00</b>	<b>98,990,527.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	359,203.00	98,990,527.00
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	-	-
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>1</b>	<b>2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>921,261,169.00</b>	<b>921,261,169.00</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	111,785,400.00	111,785,400.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,033,046,569.00	1,033,046,569.00
9	Тайлант үеийн үр дүн	(168,994,609.00)	(168,994,609.00)
<b>10</b>	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>864,051,960.00</b>	<b>864,051,960.00</b>
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-
<b>13</b>	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>864,051,960.00</b>	<b>864,051,960.00</b>
19	Тайлант үеийн үр дүн	(252,991,967.00)	(252,991,967.00)
<b>20</b>	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>611,059,993.00</b>	<b>611,059,993.00</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,940,000,000.00</b>	<b>1,808,350,732.00</b>	<b>131,649,268.00</b>	<b>93.2</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,940,000,000.00</b>	<b>1,808,350,732.00</b>	<b>131,649,268.00</b>	<b>93.2</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,940,000,000.00</b>	<b>1,808,350,732.00</b>	<b>131,649,268.00</b>	<b>93.2</b>
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,940,000,000.00</b>	<b>1,808,350,732.00</b>	<b>131,649,268.00</b>	<b>93.2</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,940,000,000.00	1,808,350,732.00	131,649,268.00	93.2
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,940,000,000.00</b>	<b>1,808,350,732.00</b>	<b>131,649,268.00</b>	<b>93.2</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,940,000,000.00</b>	<b>1,808,350,732.00</b>	<b>131,649,268.00</b>	<b>93.2</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,940,000,000.00	1,808,350,732.00	131,649,268.00	93.2

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 24,940.0 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залрууллаа.

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Он дамжин хэрэгжсэн төслийн урьдчилгаа санхүүжилтийг зардлаар бүртгэсэн	1	17,458.0			1	17,458.0	1	17,458.0				
Он дамжин хэрэгжсэн, гэрээ дүгнэсэн төслийн үлдэгдэл санхүүжилтийг өглөгөөр тусгаагүй	1	7,482.0	1	7,482.0			1	7,482.0				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>24,940.0</b>	<b>1</b>	<b>7,482.0</b>	<b>1</b>	<b>17,458.0</b>	<b>2</b>	<b>24,940.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Аудитаар нийт 857,707.8 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 811,378.3 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 46,329.5 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
АШУҮИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургуульд 21.0 сая төгрөг, Сайхан байчууд ХХК-д 4.2 сая төгрөг, Хүний эрхийн дуу хоолой ТББ-д 7.0 сая төгрөгийн төслийн 70.0 хувийн урьдчилгаа төлбөр тус тус олгосныг мөнгөн урьдчилгааны тайлан ирүүлээгүй, гэрээг дүгнэхгүйгээр зардлаар бүртгэсэн, мөн Жи Си Ай Монгол ТББ-д 21.0 сая төгрөг, Монголын Анагаах ухааны академид 31.0 сая төгрөг олгосон урьдчилгааг тооцоо нийлээгүй, урьдчилгаа санхүүжилтийн гүйцэтгэлийн тайланг ирүүлээгүй.	1	84,210.0			1	84,210.0						
Гэрээгээр гүйцэтгэсэн төслийн ажлын тайлан болон зардлын тайланг хугацаанд нь ирүүлээгүй, гэрээг дүгнүүлээгүй, гэрээний үүргээ биелүүлээгүй АШУҮИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургууль, Сайхан байчууд ХХК, Хүний эрхийн дуу хоолой ТББ, Жи Си Ай Монгол ТББ, Монголын Анагаах ухааны академи нийт 5 байгууллагын төслийн үлдэгдэл 30.0 хувийн санхүүжилт 36.1 сая төгрөгийг дараа оны төсвөөс санхүүжүүлэхээр байна.	1	36,090.0			1	36,090.0						

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Тайлант онд 4 төсөл хэрэгжүүлэгчийн 173.2 сая төгрөгийн төслийн урьдчилгаа 70.0 хувийг олгож, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.	1	173,222.7			1	173,222.7						
Өмнөх онуудад /2021 он хүртэл/ хэрэгжүүлсэн төслийн урьдчилгаа Ай Ёо Доктор ХХК-д 6.5 сая төгрөг, АШУҮИС-ТЭШ-Анагаах ухааны хүрээлэнд 49.2 сая төгрөг, Бүдүүн шулуун гэдэсний бага гэмтэлтэй МЗН-д 37.4 сая төгрөг, Ковер дизайн ХХК-д 25.2 сая төгрөг, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд 45.9 сая төгрөг тус тус олгосон санхүүжилтийн гүйцэтгэлийн тайлан ирүүлээгүй, гэрээний үүргээ биелүүлээгүйгээс он дамжин авлагаар бүртгэсэн, тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй төлбөрүүд байна	1	164,074.4								1	164,074.4	
МҮОНРТ-ийг 2023 оны 2 дугаар улиралд 179.3 сая төгрөгийн 2 төслийг хэрэгжүүлэхээр сонгон шалгаруулсан ба тус байгууллага 89.6 сая төгрөгийн төслийн гэрээний хугацааг сунгах хүсэлтийг ЭМС-ын тушаалаар баталсан хугацаанаас 1 сар 15 хоногийн дараа буюу 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдөр ирүүлсэн ба гэрээг сунгаагүй, гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулаагүй байна. Мөн 89.7 сая төгрөгийн ажлын тайланг ирүүлээгүй, гэрээний үүргээ биелүүлээгүйд арга хэмжээ аваагүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.	1	179,300.0								1	179,300.0	
Аудитын хамрах хугацаанд төслийн хэрэгжилтийн тайланг ирүүлэх ёстой 77 төслөөс 931.0 сая төгрөгийн төслийн тайланг 29 төсөл хэрэгжүүлэгч байгууллага 3 хоногоос 3 сараар хугацаа хоцроож ирүүлсэнд нийт 174.5 сая төгрөгийн гэрээний алданги тооцолгүйгээр гэрээг дүгнэсэн байна.	1	174,481.2			1	174,481.2						
ЭМДС-аас 2022 оны 3 дугаар улирлаас 2023 оны 4 дүгээр улиралд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн сонгон шалгаруулалтад төслийг ач холбогдлоор нь эрэмбэлээгүй байна.	1	-					1	-				

Өмнөх онд хэрэгжүүлсэн төслийн тайланг хугацаанд нь ирүүлээгүй байгууллагын төслийг дахин сонгон шалгаруулж, урьдчилгаа 70.0 хувийн санхүүжилт олгосон байна.	1	46,329.5					1	46,329.5				
Төслийн санал ирүүлэх аж ахуйн нэгж байгууллагад тавигдах шаардлагын дагуу улсын бүртгэлийн гэрчилгээ болон тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбарыг ирүүлээгүй 8 байгууллагуудыг шалгаруулсан байна.	1	-					1	-				
Төсөл хэрэгжүүлэгч байгууллага гэрээний хугацааг сунгуулах хүсэлтийг оройтож ирүүлсэн байна. Тухайлбал: Монголын Анагаах ухааны академи 43.4 сая төгрөгийн төслийн тайланг ЭМС-ын тушаалаар 2023 оны 3 дугаар сарын 24-ний дотор ирүүлж, гэрээг дүгнүүлэхээр баталсан ба гэрээг сунгах хүсэлтийг 2023 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр, 2 дахь удаагийн сунгалтын хүсэлтийг 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдөр тус тус ирүүлсэн байна.							1	-				
Төсөл хэрэгжүүлэгчийн ирүүлсэн тайлан болон мөнгөн урьдчилгааны тайланг журмын дагуу бүрэн бэлтгээгүй тайланг хүлээн авч гэрээг дүгнэдэг, хугацаа сунгах хүсэлт ирүүлсэн л бол сунгаснаар тооцдог, алданги тооцдоггүй зэрэг гэрээний үүргийн хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалгүй байна.	1	-			1	-						
Нийгмийн эрүүл мэндийн газар нь ЭМДС-ийн санхүүжилтээр хэрэгжсэн төслийн үр дүнг үнэлж нэгтгэн тайлагнаагүй, дүгнэлт хийдэггүй, төслийн хэрэгжилтэд явцын хяналт хэрэгжүүлдэггүй зэрэг дотоод хяналт хангалтгүй байгаагаас төсвийн хөрөнгө үр дүнгүй зарцуулах эрсдэлтэй байна	1	-			1	-						
<b>Дүн</b>	<b>12</b>	<b>857,707.8</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>6</b>	<b>438,003.9</b>	<b>4</b>	<b>46,329.5</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>373,374.4</b>

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 557,452.3 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд албан шаардлага хүргүүлээ.

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Тайлант онд 210.1 сая төгрөгийн 2 орлогын гүйлгээ, 347.3 сая төгрөгийн 13 зарлагын гүйлгээний мэдээллийг шилэн дансны цахим системд байршуулаагүй өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй	1	557,452.3	1	557,452.3		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>557,452.3</b>	<b>1</b>	<b>557,452.3</b>		